ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: САГ-2026/275/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор:Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Э.Энхбаатар<br>Утас: 51-261885 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn<br>Аудитор:Г. Сампилмаа<br>Утас:51-263533 Цахим хаяг: sampilmaag@audit.gov.mn<br>Ашид баланс Аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг<br>Утас:99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ... 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ... 14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ... 14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ... 15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 16
4. АУДИТЫН ТАЙЛАН ... 18
4.1 Ерөнхий зүйл ... 18
4.2 Материаллаг байдал ... 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ... 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ... 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 19
4.5.1 Завсрын аудитын талаар ... 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ... 21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ... 24


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ТӨХХК | Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ХХААХҮС | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд |
| ХХААХҮСХТ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.06 № 06/537
танай ____________-ны №____________-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ УТҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАТХҮҮ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 127,077.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон 22,069.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайланд онд нэр бүхий 7 байгууллагын түрээсийн 61,224.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-аас зээлээр авсан тракторын 2025 оны төлбөр 8,004.8 мянган төгрөг, хүлэмжийн төлбөр 728.2 мянган төгрөгийн гэрээ дүгнэж, тооцоо нийлэлгүй шилжүүлсэн, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-тай Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн үлдэгдэл 15,534.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Өмнөх аудитаар өгсөн 33,640.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 18 дугаар зүйлийн 18.2, 41 дүгээр зүйлийн 41.1.1, 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 42 дугаар зүйлийн 42.1, Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байх", "Үнэлгээ ба хуваарилалт", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгад бараа материалын дансны ангилал, зориулалтын дагуу бүртгээгүй бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн мод, жимсний суулгац, үр нийт 24 нэр төрлийн 7176 ширхэг буюу 42,464.6 мянган төгрөгийн хөрөнгийг биологийн хөрөнгөд, барилга байгууламж дансанд бүртгэгдсэн 11 нэр төрлийн 400 ширхэг хашаа, сүүдрэвч, хүлэмж, зөөврийн сууц нийт 215,318.5 мянган төгрөгийн хөрөнгийг бусад хөрөнгөд, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг 33,052.4 мянган төгрөгөөр залруулсан, урьдчилж гарсан зардал дансанд өмнөх онуудад үүссэн 20,201.3 мянган төгрөг зардал бүртгэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

"Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах зориулалттай 9.6 га талбайд цахилгааны шугам татах, зураг төсөв хийх" 140,500.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээ худалдан авах тухай Дүүрэн гол ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэж, ажлыг хүлээж аваагүй байна.

**Бусад асуудал**

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх" гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу finperform.mof.gov.mn программаар бэлтгэн баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлээгүй нь аудитын дүгнэлт гаргах, гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9005109
АТА16087
9025031411

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,521,806,978.98** | **1,430,632,604.37** |
| **33** | **АВЛАГА** | **193,968,978.56** | **142,205,948.73** |
| **33100** | **Ажиллагчидтай холбогдсон авлага** | | 210,945.42 |
| **33200** | **Төлбөртэй үйлчилгээний авлага** | 19,134,000.00 | 59,164,150.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 138,983,220.25 | 47,056,895.00 |
| 33500 | Бусад авлага | 35,851,758.31 | 35,773,958.31 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **20,201,250.00** | **20,201,250.00** |
| 3471 | Урьдчилж гарсан зардал | 20,201,250.00 | 20,201,250.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **1,307,636,750.42** | **1,268,225,405.64** |
| **35100** | **Түүхий эд материал** | **78,871,598.00** | **42,464,555.50** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 78,871,598.00 | 42,464,555.50 |
| **35300** | **Бэлэн бүтээгдэхүүн** | 124,333,220.00 | 119,692,340.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **1,104,431,932.42** | **1,063,183,510.14** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 842,980.00 | 1,070,333.05 |
| 35420 | Аж ахуйн материал | 56,783,907.83 | 41,574,068.83 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 2,031,000.00 | 1,279,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,135,950.00 | 1,212,153.39 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,042,638,094.59 | 1,018,047,954.87 |
| 35500 | Биологийн хөрөнгө | - | 42,885,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,531,632,159.91** | **10,014,088,554.57** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **10,531,632,159.91** | **10,014,088,554.57** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **10,263,763,760.16** | **9,747,406,821.36** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,811,537,724.00 | 7,601,333,724.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (967,513,590.45) | (1,023,371,509.83) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48,000,781.25 | 48,000,781.25 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (48,000,781.25) | (48,000,781.25) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 3,744,150,378.95 | 3,754,629,268.95 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (488,648,169.89) | (856,572,709.08) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 271,843,111.33 | 275,093,111.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (107,605,693.78) | (132,101,882.35) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 217,909,880.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (89,513,061.66) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **267,868,399.75** | **266,681,733.21** |
| 39301 | Программ хангамж | 16,050,540.61 | 16,050,540.61 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (12,870,540.86) | (14,057,207.40) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 264,688,400.00 | 264,688,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,053,439,138.89** | **11,444,721,158.94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **80,177,608.25** | **74,703,369.44** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **62,097,630.31** | **59,168,895.00** |
| **41300** | **Өглөг** | **62,097,630.31** | **59,168,895.00** |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 236,250.00 | 12,112,000.00 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 8,004,835.86 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 53,856,544.45 | 47,056,895.00 |
| **42** | **Урт хугацаат зээл** | **18,079,977.94** | **15,534,474.44** |
| 42224 | Төслийн зээл | 18,079,977.94 | 15,534,474.44 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,973,261,530.64** | **11,370,017,789.50** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,808,428,228.69** | **1,808,428,228.69** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,639,739,828.69 | 1,639,739,828.69 |
| 51101 | Эздийн өмчийн бусад хэсэг | 168,688,400.00 | 168,688,400.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **2,598,389,858.46** | **1,995,146,117.32** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,650,468,726.98 | 2,592,885,501.66 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 947,921,131.48 | (597,739,384.33) |

| | | | |
|---|---|---|---|
| **51300** | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **7,566,443,443.49** | **7,566,443,443.49** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **12,053,439,138.89** | **11,444,721,158.94** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,186,915,838.50** | **1,645,733,445.04** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,366,170,853.25** | **130,372,770.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,366,170,853.25 | 130,372,770.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 86,346,400.00 | 112,188,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 867,943,496.45 | 18,184,770.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 411,880,956.80 | - |
| **122** | **Тусламжийн орлого** | **1,820,744,985.25** | **1,515,360,675.04** |
| 12211 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,704,754,600.00 | 1,474,620,500.00 |
| 122111 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,704,754,600.00 | 1,474,620,500.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 115,990,385.25 | 40,740,175.04 |
| 122134 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 115,990,385.25 | 40,740,175.04 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,820,744,985.25** | **-** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,704,754,600.00 | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,704,754,600.00 | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **115,990,385.25** | **-** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 115,990,385.25 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,206,994,707.02** | **2,243,472,829.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,206,994,707.02** | **2,243,472,829.38** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,809,079,716.65 | 2,084,109,028.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 819,249,315.77 | 1,042,469,902.63 |
| 210101 | Үндсэн цалин | 536,820,622.83 | 613,791,987.63 |
| 210102 | Нэмэгдэл | 144,714,203.77 | 186,659,509.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 92,924,000.00 | 162,150,000.00 |
| 210104 | Урамшуулал | 44,790,489.17 | 79,868,406.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **104,133,274.02** | **131,728,897.45** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,294,694.24 | 88,047,483.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,490,658.46 | 10,547,099.01 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,177,291.30 | 7,327,567.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,834,126.05 | 5,161,349.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,336,503.97 | 20,645,398.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **106,648,717.84** | **119,390,685.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 43,202,118.24 | 62,614,863.29 |
| 210302 | Түлш, халаалт | 56,651,433.70 | 47,547,834.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,795,165.90 | 9,227,988.11 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **32,859,566.82** | **36,315,689.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,647,010.00 | 1,909,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,330,660.00 | 15,416,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,995,776.00 | 1,561,010.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,434,120.82 | 9,293,450.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,452,000.00 | 7,935,389.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **61,335,574.00** | **14,577,782.80** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,970,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 51,365,574.00 | 14,577,782.80 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,827,800.00** | **24,320,600.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 6,800,000.00 | 8,800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,027,800.00 | 15,520,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **197,838,956.00** | **118,251,840.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 181,425,044.00 | 108,313,840.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 180,912.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,233,000.00 | 4,938,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **473,186,512.20** | **597,053,630.76** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 84,495,929.39 | 53,163,062.22 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 700,000.00 | 10,607,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 387,990,582.81 | 533,282,768.54 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **397,914,990.37** | **159,363,801.23** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **6,100,000.00** | **31,164,100.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 30,164,100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,600,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **391,814,990.37** | **128,199,701.23** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 391,814,990.37 | 128,199,701.23 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **979,921,131.48** | **(597,739,384.34)** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **(32,000,000.00)** | |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | (32,000,000.00) | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН** | **947,921,131.48** | **(597,739,384.34)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **2,132,951,215.02** | **1,705,425,880.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,687,250.00** | **51,428,850.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **77,687,250.00** | **51,428,850.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | |
| 120005 | Түрээсийн орлого | 77,687,250.00 | 51,428,850.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,055,263,965.02** | **1,653,997,030.25** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,704,754,600.00 | 1,474,620,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,704,754,600.00 | 1,474,620,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 350,509,365.02 | 179,376,530.25 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 166,745,968.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 183,763,397.02 | 179,376,530.25 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,965,598,645.02** | **1,705,425,880.25** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,965,598,645.02** | **1,705,425,880.25** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,428,700,434.40 | 1,499,005,184.02 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 818,969,915.72 | 1,041,608,298.06 |
| 210101 | Үндсэн цалин | 482,108,361.78 | 519,812,867.98 |
| 210102 | Нэмэгдэл | 199,145,472.58 | 287,096,197.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 92,830,081.36 | 161,668,528.64 |
| 210104 | Урамшуулал | 44,886,000.00 | 73,030,703.52 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **104,412,674.07** | **132,801,447.44** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,524,094.29 | 89,771,592.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,490,658.46 | 11,166,004.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,177,291.30 | 6,057,102.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,884,126.05 | 5,161,349.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,336,503.97 | 20,645,398.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **106,648,717.84** | **119,043,820.47** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 43,202,118.24 | 62,614,863.29 |
| 210302 | Түлш, халаалт | 56,651,433.70 | 47,547,834.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,795,165.90 | 8,881,123.07 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,116,596.00** | **17,003,910.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,252,000.00 | 2,529,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,402,400.00 | 8,875,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,995,776.00 | 1,561,010.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,466,420.00 | 3,838,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **54,389,164.00** | **13,066,282.80** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,160,990.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 44,228,174.00 | 13,066,282.80 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,827,800.00** | **14,340,600.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 6,800,000.00 | 8,800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,027,800.00 | 5,540,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **266,062,566.77** | **103,975,775.25** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 249,648,654.77 | 99,037,775.25 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 180,912.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,233,000.00 | 4,938,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **43,273,000.00** | **57,165,050.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,473,000.00 | 39,320,050.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,800,000.00 | 17,845,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **536,898,210.62** | **206,420,696.23** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **6,100,000.00** | **31,164,100.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 1,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 30,164,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,600,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **530,798,210.62** | **175,256,596.23** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 391,814,990.37 | 128,199,701.23 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 138,983,220.25 | 47,056,895.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **167,352,570.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **167,352,570.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **167,352,570.00** | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 167,352,570.00 | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(167,352,570.00)** | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2023оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | 1,639,739,828.69 | 7,566,443,443.49 | 1,654,258,330.98 | 168,688,400.00 | 11,029,130,003.16 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (3,789,604.00) | 0.00 | (3,789,604.00) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,639,739,828.69 | 7,566,443,443.49 | 1,650,468,726.98 | 168,688,400.00 | 11,025,340,399.16 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 947,921,131.48 | | 947,921,131.48 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,639,739,828.69** | **7,566,443,443.49** | **2,598,389,858.46** | **168,688,400.00** | **11,973,261,530.64** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (5,504,356.80) | | (5,504,356.80) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,639,739,828.69 | 7,566,443,443.49 | 2,592,885,501.66 | 168,688,400.00 | 11,967,757,173.84 |
| Тайлант үеийн үр дүн | | | (597,739,384.34) | | (597,739,384.34) |
| **2025 оны12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,639,739,828.69** | **7,566,443,443.49** | **1,995,146,117.33** | **168,688,400.00** | **11,370,017,789.50** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **I** | **Нийт тэнцвэржүүлсэн ба тусламжийн дүн** | **2,077,239,100.00** | **1,419,042,958.77** | **(658,196,141,23** | **68.3** |
| **12** | **Татварын бус орлого** | **50,910,500.00** | **72,622,160.00** | **21,711,660.00** | **142.7** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 50,910,500.00 | 72,622,160.00 | 21,711,660.00 | 142.7 |
| **122** | **Татаас санхүүжилт, тусламжийн орлого** | **2,026,328,600.00** | **1,346,420,798.77** | **(679,907,801.23)** | **66.5** |
| 122005 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,026,328,600.00 | 1,346,420,798.77 | (679,907,801.23) | 66.5 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,077,239,100.00** | **1,419,042,958.77** | **(658,196,141,23** | **68.3** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,077,239,100.00** | **1,419,042,958.77** | **(658,196,141,23** | **68.3** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,035,478,300.00 | 1,387,878,858.77 | (647,599,441.23) | 68.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,166,463,900.00** | **1,031,408,298.06** | **(135,055,601.94)** | **88.4** |
| 210101 | Үндсэн цалин | 576,809,000.00 | 509,612,867.98 | (67,196,132.02) | 88.4 |
| 210102 | Нэмэгдэл | 355,953,100.00 | 287,096,197.92 | (68,856,902.08) | 80.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 160,673,400.00 | 161,668,528.64 | 995,128.64 | 100.6 |
| 210104 | Урамшуулал | 73,028,400.00 | 73,030,703.52 | 2,303.52 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **163,506,300.00** | **132,801,447.44** | **(30,704,852.56)** | **81.2** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 111,599,500.00 | 89,771,592.37 | (21,827,907.63) | 80.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,078,000.00 | 11,166,004.86 | (1,911,995.14) | 85.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,876,100.00 | 6,057,102.59 | 181,002.59 | 103.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,590,300.00 | 5,161,349.53 | (1,428,950.47) | 78.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,362,400.00 | 20,645,398.09 | (5,717,001.91) | 78.3 |
| **2103** | **Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал** | **177,594,300.00** | **119,043,820.47** | **(58,550,479.53)** | **67.0** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 59,859,500.00 | 62,614,863.29 | 2,755,363.29 | 104.6 |
| 210302 | Түлш, шатахуун | 109,497,400.00 | 47,547,834.11 | (61,949,565.89) | 43.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,237,400.00 | 8,881,123.07 | 643,723.07 | 107.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,967,500.00** | **10,903,910.00** | **(2,063,590.00)** | **84.1** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,679,400.00 | 1,329,800.00 | (349,600.00) | 79.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,850,100.00 | 6,225,000.00 | (1,625,100.00) | 79.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,720,400.00 | 1,561,010.00 | (159,390.00) | 90.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,100.00 | 200,000.00 | (100.00) | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,517,500.00 | 1,588,100.00 | 70,600.00 | 104.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,552,000.00** | **13,066,282.80** | **(12,485,717.20)** | **51.1** |
| 210604 | Урсгал засвар | 25,552,000.00 | 13,066,282.80 | (12,485,717.20) | 51.1 |
| **2107** | **Томилолт ,зочны зардал** | **2,500,100.00** | **1,290,600.00** | **(1,209,500.00)** | **51.6** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,500,100.00 | 1,290,600.00 | (1,209,500.00) | 51.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **445,331,300.00** | **60,024,950.00** | **(385,306,350.00)** | **13.5** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 439,727,600.00 | 55,086,950.00 | (384,640,650.00) | 12.5 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100.00 | | (100.00) | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 163,800.00 | - | (163,800.00) | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 39,700.00 | - | (39,700.00) | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,400,100.00 | 4,938,000.00 | (462,100.00) | 91.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **41,562,900.00** | **19,339,550.00** | **(22,223,350.00)** | **46.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,312,800.00 | 19,089,550.00 | (22,223,250.00) | 46.2 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн, дадлага хийх | 250,100.00 | 250,000.00 | (100.00) | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,760,800.00** | **31,164,100.00** | **(10,596,700.00)** | **74.6** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 41,760,800.00 | 31,164,100.00 | (10,596,700.00) | 74.6 |
| 213204 | Ажил олгогчоос олгох, шагнал | 9,652,900.00 | 1,000,000.00 | (8,652,900.00) | 10.4 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж | 30,807,900.00 | 30,164,100.00 | (643,800.00) | 97.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,300,000.00 | - | (1,300,000.00) | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **34** | **34** | **0.00** | **100** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 0.00 | **100** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | **100** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 33 | 33 | 0.00 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31 | 31 | 0.00 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | 0.00 | 100 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **Нийт тэнцвэржүүлсэн ба тусламжийн дүн** | - | **158,183,220.25** |
| **12** | **Татварын бус орлого** | | |

| | | | |
|---|---|---|---|
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 158,183,220.25 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 158,183,220.25 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **158,183,220.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **158,183,220.25** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 111,126,325.25 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл | - | 10,200,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | - | 10,200,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 6,100,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 1,200,000.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | - | 2,650,000.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | - | 2,250,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **13,050,000.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 8,800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 4,250,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | - | **43,950,825.25** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 43,950,825.25 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | **37,825,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 20,230,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 17,595,000.00 |
| **4** | **Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл** | - | **47,056,895.00** |
| **5** | **Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **-** | **(47,056,895.00)** |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (47,056,895.00) |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв УТҮГ нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн тогтвортой өсөлтийг шинжлэх ухааны ололтоор түүчээлэн дэлхийн энтэй хөгжүүлэхэд оршино" гэж тодорхойлон дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд технологи нэвтрүүлэх, хүнсний ногооны үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг хангахад чиглэсэн сургалт, мэдээллийг хүргэх, шинэ нэр төрлийн таримлын сортыг турших;
- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, махны экспортыг нэмэгдүүлэх судалгаа, туршилт хийх;
- Загвар аж ахуйг хөгжүүлэх, чадамжийг дээшлүүлэх.

Тус төв нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн салбарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Эрдэм шинжилгээ, судалгаа туршилт, инкүбаци, шинжлэх ухааны ололт дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах, сурталчлах, мэдээ мэдээллээр хангах;
- Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа хөгжлийн төв УТҮГ нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд  өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Малчны тухай хууль;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Монгол хэлний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчлэн батлагдсан байна.

Төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Тайлант хугацаанд дээд шатны төсвийн захирагчаас хяналт ороогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/385 дугаар тушаалаар баталсан "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байгаа боловч холбогдох хууль тогтоомж, журмын шинэчлэл өөрчлөлтийг тухай бүр тусгаагүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв УТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай";

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 608,718.0 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 193,969.0 | 142,205.9 | (51,763.0) |
| Урьдчилж гарсан зардал | 20,201.3 | 20,201.3 | 0.0 |
| Бараа материал | 1,307,636.8 | 1,268,225.4 | (39,411.3) |
| Үндсэн хөрөнгө | 10,531,632.2 | 10,014,088.6 | (517,543.6) |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **12,053,439.1** | **11,444,721.2** | **(608,718.0)** |
| Богино хугацаат өр төлбөр | 62,097.6 | 59,168.9 | (2,928.7) |
| Урт хугацаат өр төлбөр | 18,080.0 | 15,534.5 | (2,545.5) |
| Засгийн газрын хувь оролцоо | 11,973,261.5 | 11,370,017.8 | (603,243.7) |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **12,053,439.1** | **11,444,721.2** | **(608,718.0)** |

- Авлага дансны үлдэгдэл 51,763.0 мянган төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний байгууллагаас авах авлага 40,030.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, татаас санхүүжилтийн авлага 91,926.3 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн;
- Бараа материалын үлдэгдэл 1,268,225.4 мянган төгрөг болж, 39,411.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 41,919,9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 81,331.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсан.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 517,543.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардал тооцсонтой холбоотой
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 59,168.9 мянган төгрөг болж, 2,928.7 мянган төгрөгөөр буурсан нь бараа, үйлчилгээний төлбөр 11,875.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өр төлбөр 8,004.8 мянган төгрөг, байгууллагын өр төлбөр 6,799.6 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн;
- Урт хугацаат өр төлбөр 15,534.5 мянган төгрөг болж 2,545.5 мянган төгрөгөөр буурсан нь төслийн зээл төлөгдсөнтэй холбоотой;

- Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 603,243.7 мянган төгрөгөөр буурсан.

Тус төвийн биет бус хөрөнгийн дансанд Дата ланд технологи ХХК-ийн ХХААХҮЯ болон төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа газруудын төсвийн нэгдсэн (https://auth-mofa.opengov.mn/login) системд 4,278.0 мянган төгрөг , Хас эрин орчил ХХК-ийн www.vet.dynamic.mn онлайн санхүүгийн программ бүртгэлтэй, тайлант онд программын үйлчилгээний төлбөр 660.0 мянган төгрөгийн төлбөрийг тус тус төлсөн байна. Санхүүгийн байдлын тайланд программ хангамж 1,993.3 мянган төгрөгийн бүртгэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,301,378.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 50,910.5 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 2,352,288.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас мал аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл хөгжүүлэх арга хэмжээний зардлыг 275,049.8 мянган төгрөгөөр бууруулж, 2,077,239.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,346,420.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 72,622.2 мянган төгрөг, нийт 1,419,042.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал зардалд 1,419,042.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,419,042.2 мянган төгрөг буюу 68.3 хувь байгаа нь газар тариалан хөгжүүлэх 349,000.0 мянган төгрөг, хөнгөн үйлдвэр хөгжүүлэх 24,211.5 мянган төгрөг, хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага 284,984.7 мянган төгрөг нийт 658,196.1 мянган төгрөгийг хөтөлбөр арга хэмжээний зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | **Нийт дүн** | **2,077,239.1** | **1,419,042.9** | **(658,196.2)** | **68.3** |
| 1 | **70802 газар тариалан хөгжүүлэх** | **349,000.0** | **-** | **(349,000.0)** | **-** |
| | 82555 Хүнсний хангамж аюулгүй байдал | 349,000.0 | - | (349,000.0) | - |
| 2 | **70804 хөнгөн үйлдвэр хөгжүүлэх** | **24,211.5** | **-** | **(24,211.5)** | - |
| 2.1 | 82539 хөнгөн үйлдвэрийн үндэсний хөтөлбөрүүд | 24,211.5 | - | (24,211.5) | - |
| 3 | **70805 Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага** | **1,704,027.6** | **1,419,042.9** | **(284,984.7)** | **83.3** |
| 3.1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,554,592.1 | 1,319,644.8 | (234,947.3) | 84.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3.2 | 80202 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 41,760.8 | 32,164.1 | (9,596.7) | 77.0 |
| 3.3 | 80215 Эрдэм шинжилгээ судалгааны ажил | 41,158.6 | 17,935.5 | (23,223.1) | 43.6 |
| 3.4 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 66,516.1 | 49,298.5 | (17,217.6) | 74.1 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зарлагын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

ХХААХҮС-ын 2025 оны А/442 дугаар тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоог захирал 1, захиргааны хэлтэс 9, эрдэм шинжилгээний, судалгаа, туршилтын хэлтэс 9, инноваци нэвтрүүлэлтийн хэлтэс 9, төв лаборатори 5, нийт 33 албан хаагч, ажилтантай байхаар баталсан. Гүйцэтгэлээр удирдлага 1, гүйцэтгэх ажилтан 29, үйлчилгээний ажилтан 3, нийт 33 албан хаагч, ажилтан ажиллаж байна.

Төвийн захирлын 2025 оны Б/29 дүгээр тушаалаар цалингийн шатлал, төрийн албаны нэмэгдэл, нэг ажилтанд ногдох өдрийн хоол 28.0 мянган төгрөг, унаа 3.0 мянган төгрөг олгохоор баталсан байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтөд нийт 162,150.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд томилолт 2,500.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, чадавхжуулах хүрээнд 4 заалт бүхий төлөвлөгөө гаргаж, байгууллага дээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт "Сургалт-мэдээллийн цаг"-ийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээ зардал гараагүй, төрд учирсан хохирлын төлбөрийн асуудал байхгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 158,183.2 мянган төгрөгийн орлого бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос гэрээт ажлын хөлс, цалин 10,200.0 мянган төгрөг, бичиг хэрэг, хангамжийн зардал 6,100.0 мянган төгрөг, томилолт 13,050.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж 43,950.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 43,950.8 мянган төгрөг нийт 117,251.7 мянган төгрөгийг зарцуулж, 47,56.9 мянган төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлж санхүүжилтийн авлага бүртгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус төвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны А/23 дугаар тушаалаар 150,000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар “Дүүрэн гол” ХХК шалгарч, 2025 оны ХХААХҮСХТ/20250101004 дугаартай “Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах ХАА-н цогцолбор байгуулах зориулалттай 9.6 га талбайд цахилгааны шугам татах зураг төсөв хийх, шугам татах” гэрээг 140,500.0 мянган төгрөгөөр байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих болон шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Ашид баланс Аудит” ХХК-ийн Ахлах аудитор Д.Алтанцэцэг, аудитор Т.Баясгалан, туслах аудитор Б.Доржсүрэн нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Оюунчимэг, захирал Л.Майцэцэг анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Сампилмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц,Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийлсэн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,206,994.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 22,069.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалт, шаардлага горимын дагуу төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих зөвлөмж өгөв.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст нийт 3,591,027.6 мянган төгрөгийн 64 мэдээлэл байршуулахаас , цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19 мэдээлэл 1,667,304.0 мянган төгрөг, зарлагын 15 мэдээлэл 123,709.9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 175,493.2 мянган төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 175,493.2 мянган төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулах, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, бараа материал, нийгмийн даатгалын өглөгийн данстууд болон өмнөх зөвлөмж, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулан, асуудлын бүртгэлээр баталгаажуулж 315,835.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 146,512.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 146,512.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд аудитын шийдвэр 77.0 хувийн биелэлттэй гарсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 146,512.6 | 2 | 112,872.1 | 77.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зөвлөмж | 1 | | | | |
| **Нийт дүн** | **4** | **146,512.6** | **2** | **112,872.1** | **77.0** |

Өмнөх онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц боломжоор тусган шинэчлэх зөвлөмж, авлагын тооцоог харилцагч бүртэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлийг зөв хөтлөөгүй 33,640.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу Засгийн газрын finperform.mof.gov.mn санхүүгийн программаар 2025 оны санхүүгийн тайлан бэлтгэхэд программын шинэчлэлт жигдрээгүй, тайлан баталгаажуулахад хүндрэлтэй байлаа.

Тус төвийн “Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд байрлах хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах зориулалттай 9.6 га талбайд цахилгааны шугам татах, зураг төсөв хийх” ХХААХҮСХТ/20250101004 дугаартай тендерийн гүйцэтгэгч “Дүүрэн гол” ХХК-ийн гэрээ дүгнэж, бүртгэлд тусгасан эсэхийг хянах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 229,976.6 мянган төгрөгийн 5 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Биологийн хөрөнгө болох мод, жимсний суулгац, үр нийт 24 нэр төрлийн 7176 ширхэг буюу 90,670.7 мянган төгрөгийн хөрөнгийг тусгай зориулалт, аж ахуйн материал дансанд бүртгэсэн, УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга-д “Үнэн зөв байх”, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй;
- Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөр 5,000.0 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй, УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга-д “Үнэн зөв байх”, “Оршин байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтад тусгагдсан элэгдэл тооцох жилийн хувь хэмжээг баримтлаагүй Борнуурын зоорь, үйлдвэрийн барилга, худгийн элэгдлийн тооцооллыг 33,052.4 мянган төгрөгөөр илүү тооцоолж зардал өсгөсөн, “Үнэн зөв байх”, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй;
- Хөрөнгийн дахин үнэлгээний 89,985.5 мянган төгрөгийн бүртгэлийн бичилтийг буруу тайлагнасан, УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга-д “Үнэн зөв байх”, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй
- Хөдөө аж ахуйн корпораци ХХК-ийн 2025 онд төлөх зээлийн төлбөр 8,004.8 мянган төгрөг, хүлэмжийн төлбөр 728.2 мянган төгрөг, Улаанбаатар дулааны сүлжээ Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн төлбөр 2,587.4 мянган төгрөг нийт 11,268.1 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнаж зардлын ангиллыг буруу бүртгэсэн, УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга-д “Үнэн зөв байх”, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 127,077.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 93,436.5 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 33,640.5 мянган төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 127,077.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 105,007.1 мянган төгрөгөөр давсан тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Хан-уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 183/ШШ20223454 дүгээр шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны 2023 оны 2010/МА2023/00521 дүгээр шийдвэрээр 1 иргэнд олгох ажилгүйдлийн тэтгэмж 7,272,3 мянган төгрөгийн төсөвлөөгүй зардлыг нэмэлт санхүүжилтээс олгосон байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*, 41 дүгээр зүйлийн 41.2.2 *"батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах , нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих тухай журмын 1 дүгээр зүйлийн 1.5 *“Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бусад төсөвт байгууллага, хувь хүнд шилжүүлэх, олгох зэргээр зарцуулахыг хориглоно*” заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, шүүхийн шийдвэрээр ажилгүйдлийн тэтгэмж олгосон зөрчлийг таслан зогсоох.

2. Тайланд онд нэр бүхий 7 байгууллагын түрээсийн 61,224.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Түрээсийн авлага барагдуулаагүй зөрчлийг арилгах.

3. Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-с зээлээр авсан тракторын 2025 оны төлбөр 8,004.8 мянган төгрөг, хүлэмжийн төлбөр 728.2 мянган төгрөгийг тус тус тооцоо нийлэлгүй шилжүүлсэн, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-тай Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн үлдэгдэл 15,534.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 *”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх”,* Тариалан эрхлэх дэмжих сангийн 2019 оны ТХААМ-2019/003 дугаар гэрээний ерөнхий нөхцөл 1.40 “гэрээний гүйцэтгэлийг худалдан авагч нь худалдагч талын гэрээ байгуулсан мэргэжилтэнтэй 12 дугаар сарын 15-ны дотор дүгнэн акт үйлдэж баталгаажуулсан байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-аас авсан трактор, хүлэмжийн зээлийн гэрээг дүгнэж, тооцоо нийлэлгүй төлбөрийг шилжүүлсэн, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-тай Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлийг арилгах.

4. НББ-ийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоор тусган шинэчлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана*”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан,*

*санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтуудтай нийцэтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийг тусган батлаагүй зөрчлийг арилгах.

5. Өмнөх оны аудитаар өгсөн 33,640.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 41 дүгээр зүйлийн 41.2.1 *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах.

6. Байгууллагад бүртгэлтэй 29-17 УБЧ улсын дугаартай, Hyundai Starex маркын суудлын автомашины 2020-2025 оны 672.5 мянган төгрөгийн Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг төлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Монгол улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 "Аж ахуйн нэгж, байгууллага авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг хугацаандаа төлөөгүй зөрчлийг арилгах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Биологийн хөрөнгө болох мод, жимсний суулгац, үр нийт 24 нэр төрлийн 7176 ширхэг буюу 90,670.7 мянган төгрөгийн хөрөнгийг тусгай зориулалт, аж ахуйн материал дансанд тус тус бүртгэсэн | 1 | 90,670.7 | | | | | 1 | 90,670.7 | | | | |
| 2 | 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөрийг бүртгээгүй | 1 | 5,000.0 | | | | | 1 | 5,000.0 | | | | |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтад тусгагдсан элэгдэл тооцох жилээс Борнуурын зоорь, үйлдвэрийн барилга, худгийн элэгдлийн тооцооллыг 33,052.4 мянган төгрөгөөр илүү тооцоолж зардал өсгөсөн. | 1 | 33,052.4 | | | | | 1 | 33,052.4 | | | | |
| 4 | Хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 1 | 89,985.4 | | | | | 1 | 89,985.4 | | | | |
| 5 | Хөдөө аж ахуйн корпораци ХХК-ийн 2025 онд төлөх | 1 | 11,268.1 | | | | | 1 | 11,268.1 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зээлийн төлбөр 8,004.8 мянган төгрөг, хүлэмжийн төлбөр 728.2 мянган төгрөг, Улаанбаатар дулааны сүлжээ Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн төлбөр 2,587.4 мянган төгрөг нийт 11,268.1 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тайлагнаж зардлын ангиллыг буруу бүртгэсэн | | | | | | | | | | | | |
| | Дүн | 5 | 229,976.6 | | | | | 5 | 229,976.6 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| 1 | Хан-уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2022 оны 183/ШШ20223454, Нийслэлийн давж заалдах шатны 2023 оны 03 дугаар сарын10-ны өдрийн 2010/МА2023/00521 дугаар шийдвэрээр иргэн П.Насанжаргалд олгох ажилгүйдлийн тэтгэмж 7,272,3 мянган төгрөгийн | 1 | 7,272,3 | | | 1 | 7,272,3 | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөвлөгдөөгүй зардлыг нэмэлт санхүүжилтээс олгосон байна. | | | | | | | | | | |
| 2 | Тайланд онд нэр бүхий 7 байгууллагын түрээсийн 61,224.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. | 1 | 61,224.2 | | | 1 | 61,224.2 | | | | |
| 3 | Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-с зээлээр авсан тракторын 2025 оны төлбөр 8,004.8 мянган төгрөг, хүлэмжийн төлбөр 728.2 мянган төгрөг тус тус тооцоо нийлэлгүй шилжүүлсэн, Улаанбаатар дулааны сүлжээ байгууллагатай Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн үлдэгдэл 15,534.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 24,267.6 | | | 1 | 24,267.6 | | | | |
| 4 | Байгууллагад бүртгэлтэй улсын 2917УБЧ дугаартай Hyundai Starex суудлын автомашины 2020-2025 оны 672,500.00 /зургаан зуун далан хоёр мянга таван зуун/ төгрөгийн Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг төлөөгүй байна. | 1 | 672.5 | | | 1 | 672.5 | | | | |
| 5 | НББ-ийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоор тусган шинэчлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | | | | 1 | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Өмнөх оны аудитаар өгсөн 33,640.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1 | 33,640.5 | | | | | | | 1 | 33,640.5 |
| | **Дүн** | **6** | **127,077.0** | | | **5** | **93,436.5** | | | **1** | **33,640.5** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудаст нийт 3,591,027.6 мянган төгрөгийн 64 мэдээлэл байршуулахаас , цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 19 мэдээлэл 1,667,304.0 мянган төгрөг, зарлагын 15 мэдээлэл 123,709.9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож, зарлагын гүйлгээний 175,493.2 мянган төгрөгийн 6 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 175,493.2 | | | 1 | 175,493.2 |
| | **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил** | | | | | | |
| 1 | Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 2 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солих ажлын зохион байгуулаагүй | 1 | | | | 1 | |
| **2** | **Дүн** | **2** | **175,493.2** | | | **2** | **175,493.2** |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 491/A0150079 Улаанбаатар хот

САГ-2026/275/ИА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хан-уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 183/ШШ20223454 шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны 2023 оны 2010/МА2023/00521 дугаар шийдвэрээр иргэн П.Насанжаргалд олгох ажилгүйдлийн тэтгэмж 7,272,340.00(долоон сая хоёр зуун далан хоёр мянга гурван зуун дөчин) төгрөгийн төсөвлөөгүй зардлыг нэмэлт санхүүжилтээс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах , нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих тухай журмын 1 дүгээр зүйлийн 1.5-д "*Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг бусад төсөвт байгууллага, хувь хүнд шилжүүлэх, олгох зэргээр зарцуулахыг хориглоно*" заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.6 "*төсвийг зориулалт бусаар зарцуулсан* " гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, шүүхийн шийдвэрээр ажилгүйдлийн тэтгэмж олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Б.Батхүү/, Ерөнхий нягтлан бодогч /Я.Болдбаатар/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*



1526181030

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 492/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/275/НА-СТА-ТШЗ

Хариуцлага тооцох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн 33,640,461.31(гучин гурван сая зургаан зуун дөчин мянга дөрвөн зуун жаран нэгэн төгрөг, гучин нэгэн мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, 41 дүгээр зүйлийн 41.2.1 *"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*" 42 дугаар зүйлийн 42.1. "*Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно*" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зөрчил гаргасан буруутай албан тушаалтан ерөнхий нягтлан бодогч /Я.Болдбаатар/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, дүгнэлт гаргаснаас хойш 1 сарын дотор хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Б.Батхүү/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-85.Docx

1526181028

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 487/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/275/НА-СТА-ПШ 3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-с зээлээр авсан тракторын 2025 оны төлбөр 8,004,835.86 (найман сая дөрвөн мянга найман зуун гучин таван төгрөг, наян зургаан мөнгө) төгрөг, хүлэмжийн төлбөр 728,246.00 (долоон зуун хорин найман мянга хоёр зуун дөчин зургаан) төгрөгийг гэрээ дүгнэж, тооцоо нийлэлгүй шилжүүлсэн.

Улаанбаатар дулааны сүлжээ байгууллагатай Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн үлдэгдэл 15,534,471.44 (арван таван сая таван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун далан нэгэн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх",* Тариалан эрхлэх дэмжих сангийн 2019 оны ТХААМ-2019/003 дугаар гэрээний ерөнхий нөхцөл 1.40 "гэрээний гүйцэтгэлийг худалдан авагч нь худалдагч талын гэрээ байгуулсан мэргэжилтэнтэй 12 дугаар сарын 15-ны дотор дүгнэн акт үйлдэж баталгаажуулсан байна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.7-д "*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй*" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-с авсан трактор, хүлэмжийн зээлийн гэрээг дүгнэж, тооцоо нийлэлгүй төлбөрийг шилжүүлсэн, Улаанбаатар дулааны сүлжээ байгууллагатай Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Б.Батхүү/, Ерөнхий нягтлан бодогч /Я.Болдбаатар/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 489/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/275/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад бүртгэлтэй улсын 2917УБЧ дугаартай Hyundai Starex суудлын автомашины 2020-2025 оны 672,500.00 /зургаан зуун далан хоёр мянга таван зуун/ төгрөгийн Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг төлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Монгол улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварыг хугацаандаа төлөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Б.Батхүү/, Ерөнхий нягтлан бодогч /Я.Болдбаатар/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-85.Docx

1526181034

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 488/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/275/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоор тусган шинэчлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"*, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 *"Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"* гэсэн заалтуудтай нийцэтгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1 *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"* гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, бодлогын баримт бичгийг стандартын дагуу шинэчлээгүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Б.Батхүү/, Ерөнхий нягтлан бодогч /Я.Болдбаатар/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-85.Docx

1526181038

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 490/А0150079 Улаанбаатар хот

САГ-2026/275/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд нэр бүхий 7 байгууллагын түрээсийн 61,224,160.00 /жаран нэгэн сая хоёр зуун хорин дөрвөн мянга нэг зуун жаран/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.7-д "*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй*" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээсийн авлага барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, зөрчлийг таслан зогсоох биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал /Б.Батхүү/, Ерөнхий нягтлан бодогч /Я.Болдбаатар/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э. ЭНХБААТАР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

9005107
АГА16037
9025031411